



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 123

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах
тухай

Монгол Улсын Их Хурлын даргын 2015 оны 22 дугаар захирамжийг үндэслэн
ТУШААХ нь:

1. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Парламентын Ассамблейн намрын хурлыг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо 2015 оны 09 дүгээр сард зохион байгуулах болсонтой холбогдуулан эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, зохицуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хийх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Үндэсний хорооноос өгсөн чиглэлийн дагуу ажиллаж ажлын хэсгийг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах, бэлтгэл ажлыг чанартай хийж хурлын үеэр үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга /О.Баяр/-д даалгасугай.
3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Ганчимэг/-д үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080416

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03 сарын 31 өдрийн
123 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга :

Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн дарга

Гишүүд:

Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга

Эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн
тусламж үйлчилгээний бодлогын
хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан
мэргэжилтэн

Яаралтай ба түргэн тусламж
үйлчилгээний бодлогын хэрэгжилтийн
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын
орлогч дарга

Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн
дарга

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03 сарын 31 өдрийн
123 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийх ажлууд	хугацаа	Хариуцах эзэн
1	Ажлын хэсгийг байгуулах	2015.03 сар	Г.Ганчимэг
2	Ажлын хэсгийн уулзалт хийж гишүүдэд мэдээлэл өгч, үүрэгжүүлэх	2015.03 сар	О.Баяр
3	Ажлын төлөвлөгөө гаргах	2015.03 сар	Л.Зэндмаа
4	Ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж цаг үеийн мэдээллээр хангах	Сар бүр	О.Баяр
5	УХТЭ дээр хурал болох хугацаанд хоёр палатыг байнгын бэлэн байдалд байлгах	2015. 09 сар	Н.Баясгалан
6	Хурлын үеэр тус палатыг хариуцан ажиллах эмч нарын хуваарийг гаргаж баталгаажуулах	2015.08 сар	Н.Баясгалан
7	Хурлын үеэр ажиллах бүрэн тоноглол бүхий түргэн тусламжийн машиныг бэлтгэх	2015.09 сар	Ц.Пүрэвдаш
8	Хурлын үеэр ажиллах түргэн тусламжийн эмч нарын хуваарийг гаргаж баталгаажуулах	2015.08 сар	Ц.Пүрэвдаш
9	Шаардлагатай эм, тарианы тооцоог хийж бэлэн байдлыг хангах	2015.08 сар	Н.Баясгалан
10	Бэлтгэл ажилтай танилцах	2015.08 -09 сар	О.Баяр